



НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2017 оны 06 сарын 06 өдөр

Дугаар А/50

Улаанбаатар хот

Г Зочид буудал, дэн буудал, амралтын
газрын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл
олгох, цуцлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь заалт, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2011 оны 120 дугаар тогтоолоор батлагдсан "Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам"-ын 5.1, Нийслэлийн Аялал жуулчлалын газрын дүрмийн 2.5.3-т заасныг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. "Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам" болон "Зочид буудалд тавигдах ерөнхий шаардлага MNS 4588:2008" стандартын шаардлагыг хангасан, энэ тушаалын нэгдүгээр хавсралтад дурдсан аж ахуйн нэгжид зочид буудлын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг нэг жилийн хугацаатай олгосугай.

2. "Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам" болон "Дэн буудалд тавигдах ерөнхий шаардлага MNS 5738:2007" стандартын шаардлагыг хангасан, энэ тушаалын хоёрдугаар хавсралтад дурдсан аж ахуйн нэгж, иргэнд дэн буудлын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг нэг жилийн хугацаатай олгосугай.

3. Энэ тушаал гарсантай холбогдуулан Ансен ХХК-ны "Ану-Үжин" зочид буудлын 13/211, Мон девелопмент ХХК-ны "Вайт хаус" зочид буудлын 13/172, БодЭнх ХХК-ны "Очир" зочид буудлын 14/019, Ариг-Эрдэнэ ХХК-ны "Нова" зочид буудлын 15/012, Зол халиун Соронз ХХК-ны "Соронз" зочид буудлын 16/024, Хоссүмбэр ХХК-ны "Хос" дэн буудлын 14/63, Хоссүмбэр ХХК-ны "Окэй" дэн буудлын 14/62, Зуно ХХК-ны "Генерал" дэн буудлын 13/192, Иргэн Г.Идэрзориг "Говь" дэн буудлын 15/063, Иргэн М.Тунгалаг "Тайж" зочид буудлын 13/266 тоот гэрчилгээг хүчингүй болсонд тооцсугай.

4. Гэрчилгээний үнэ болох 5000 /таван мянга/ төгрөгийг Төрийн сан банкны 100200051053 тоот дансанд төвлөрүүлэн, зөвшөөрлийн гэрчилгээний бичилт, олголтод хяналт тавьж ажиллахыг ахлах нягтлан бодогч /Б.Батбаатар/-д даалгасугай.

5. Зөвшөөрөл авсан байгууллага болон иргэдтэй гэрээ байгуулж үр дүнг тооцон ажиллахыг Захиргааны хэлтэс /Д.Ганболд/-д үүрэг болгосугай.

6. Энэхүү тушаалыг Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар, Нийслэлийн Цагдаагийн газар болон дүүргүүдийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлэхийг хяналт, шинжилгээ, үнэлгээ хариуцсан мэргэжилтэн /Б.Огонсувд/-д үүрэг болгосугай.



Нийслэлийн Аялал жуулчлалын газрын даргын 2017 оны 06 сарын 06 өдрийн дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

1117139265
УОА0453 5284325

ЗОЧИД БУУДЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ
ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ АЖ АХУЙН НЭГЖИЙН
ЖАГСААЛТ

2017.06.06

Улаанбаатар хот

Д/д	Иргэн, аж ахуйн нэгжийн нэр	Эзэмшигчийн регистрийн дугаар	Оноосон нэр	Байршил
1	Ансен ХХК	2662159	Ану-Ужин	БЗД-ийн 3-р хороо ЭТӨЧ-29
2	Мон девелопмент ХХК	2804433	Вайт хаус	БГД-ийн 17-р хороо Амарсанаагын гудамж
3	БодЭнх ХХК	5055733	Очир	БГД-ийн 17-р хороо Жалханзхутагт Дамдинбазарын гудамж
4	Ариг-Эрдэнэ ХХК	2543192	Нова	БГД-ийн 20-р хороо ЭТӨЧ-296/3
5	Зол халиун Соронз ХХК	4552318	Соронз	БНД-ийн 4-р хороо Жаргалантын 1-1
6	Гамба ХХК	2829282	Хорека	БЗД-ийн 14-р хороо ЭТӨЧ-79
7	Иргэн М.Тунгалаг	ЧР65071566	Тайж	БЗД-ийн 7-р хороо Доржийн гудамж-3
8	Сэруулэг конструкшн ХХК		Би Ти	СБД-ийн 1-р хороо Чингисийн өргөн чөлөө-106

--ooOoo--

Нийслэлийн Аялал жуулчлалын
газрын даргын 2017 оны 06 сарын 06
өдрийн 11:50 дугаар тушаалын
хоёрдугаар хавсралт

1117139265
УОА0453 5284325

ДЭН БУУДЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ
ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ АЖ АХУЙН НЭГЖИЙН
ЖАГСААЛТ

2017.06.06

Улаанбаатар хот

Д/д	Иргэн, аж ахуйн нэгжийн нэр	Эзэмшигчийн регистрийн дугаар	Оноосон нэр	Байршил
1	Зуно ХХК	2732394	Генерал	БЗД-ийн 16-р хороо Дандарын гудамж-20
2	Хоссүмбэр ХХК	5288886	Окэй	БГД-ийн 16-р хороо Орхоны 5-19
3	Хоссүмбэр ХХК	5288886	Хос	БГД-ийн 16-р хороо Орхоны 5-22
4	Иргэн Г.Идэрзориг	Ц386021571	Говь	БЗД-ийн 4-р хороо АОС-4
5	Иргэн Д.Мягмарсүрэн	ШГ83032991	Комфорт	СХД-ийн 28-р хороо Ногоончулуут 1-36

--ooOoo--